



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 11 өдөр

Дугаар A/124

Жаргалант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн ээлжит гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Норовлин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1.1, 2.1.1.4, 2.2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн Спорт заалны дээвэр 2023 оны хаврын хүчтэй салхинд хууларч үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон тул засварт шаардагдах 4500000 (дөрвөн сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.“Эрүүл чийрэг бүтээлч монгол хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэгийн ахлах бэлтгэл бүлгийн 4-5 настай хүүхдийг хөгжүүлэх “СТЕМ” тоглоомыг авахад шаардагдах 5677000 (таван сая зургаан зуун далан долоон мянга) төгрөгийг зарцуулсугай.

3.Сургуулийн бөхийн секц хичээллүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдаж авахад 396000 төгрөг, Хэнтий аймгийн Норовлин сумын Засаг даргын ивээл дор зохион байгуулагдах үндэсний бөхийн өсвөр үеийн сумын аварга шалгаруулах барилдааны шагналд 1160000 төгрөг, нийт 1556000 (нэг сая таван зуун тавин зургаан мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

4.Дээрх зардалд шаардагдах нийт 11733000 (арван нэгэн сая долоон зуун гучин гурван мянга) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас гаргахыг нягтлан бодогч (Л.Энхдорж)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232501289